

## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 9 сарын 10-ны өдөр

№ 21/35

Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн чөлөөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.11 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.10.1 дэх заалт, Компанийн ТУЗ-ийн 9 сарын 10-ны өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Болд овогтой Өлзийбаяр нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 сарын 11-ний өдрийн 225 тоот “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, мөн 2021 оны 6 сарын 11-ний өдрийн 226 тоот “Компанийн өрийн хэрэгсэл бүртгэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтад тус тус заасан шаардлагын дагуу Компанитай аливаа ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх үүднээс 2021 оны 9 сарын 8-ны өдөр ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн байх тул уг хүсэлтийг хүлээн авч, энэхүү тогтоол гарсан өдрөөр тус гишүүний бүрэн эрхийг зогсоож, Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөх асуудлыг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлүүлэхээр тогтоосугай.
2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Болд овогтой Өлзийбаярын бүрэн эрхийг зогсоож буйтай холбогдуулан ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээдийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу зохион байгуулж, үр дүнг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Болд овогтой Өлзийбаяр нь чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж, түүний бүрэн эрхийг зогсоож буй тухай мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олон нийтэд мэдээлж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

УЛААНБААТАР ХОТ  
5039754 ☎ 1118267206